



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 1159

Нсөнбузаг

Засаг даргын нэрэмжит аймгийн аварга
шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор
тэмцээнийг зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний ажил үйлчилгээ-1-ийн 1.7 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын мөнгөн төлбөр зарцуулах журмын 4 дүгээр хэсгийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулж явуулсугай.

2. Тэмцээн зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, зааврыг гуравдугаар, тэмцээнд шаардагдах шагнал урамшууллын зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээний нэгдүгээр шатыг орон нутагтаа зааврын дагуу зохион байгуулж дүнг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны дотор мэдээлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


4. Тэмцээний бэлтгэл болон зохион байгуулах үеийн арга хэмжээний хөтөлбөр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсэг (хурандаа Д.Төмөрбаатар), батлагдсан удирдамж заавар, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, хөдөлгөөний үеийн аюулгүй ажиллагааны болон бусад холбогдох дүрэм журмыг сайтар мөрдүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт хариуцуулсугай.

5. Тэмцээнд зарцуулагдах 3608000 (гурван сая зургаан зуун найман мянган) төгрөгийг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

6. Тэмцээнийг зохион байгуулж явуулахад бүх талын дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж, дүнг илтгэхийг ажлын хэсэг (хурандаа Д.Төмөрбаатар)-г үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР





تعمیرات - سرفیس و رنگ آمیزی
کارگاه تخصصی رنگ آمیزی

شماره پرونده: ۰۰۰۰۰۰۰۰

تاریخ: ۰۰/۰۰/۰۰

شماره سند: ۰۰۰

تاریخ سند: ۰۰/۰۰/۰۰

محل: ۰۰

تلفن: ۰۰۰۰۰۰۰۰۰

گواهی
کارگاه تخصصی رنگ آمیزی
تعمیرات و نگهداری سازه های فلزی
تعمیرات و نگهداری سازه های فلزی

این کارگاه تخصصی رنگ آمیزی، فعالیت خود را در زمینه تعمیرات و نگهداری سازه های فلزی در سال ۱۳۸۰ آغاز کرده و در طی این مدت با بهره گیری از روش های نوین و استفاده از بهترین مواد و تجهیزات، موفق شده است تا خدماتی با کیفیت و در حد استانداردهای بین المللی را به مشتریان عزیز ارائه دهد. کارگاه تخصصی رنگ آمیزی، دارای مجوزهای لازم از مراجع ذیصلاح بوده و کلیه خدمات خود را مطابق با استانداردهای بین المللی ارائه می دهد.

۱. رنگ آمیزی سازه های فلزی: این کارگاه تخصصی، با استفاده از بهترین رنگ های پودری و روغنی، سازه های فلزی را از خوردگی و زنگ زدگی محافظت می دهد. همچنین با استفاده از رنگ های ضد آلودگی، سازه های فلزی را از آلودگی و کثیف شدن محافظت می دهد.

۲. تعمیرات و نگهداری سازه های فلزی: این کارگاه تخصصی، با استفاده از روش های نوین و استفاده از بهترین تجهیزات، تعمیرات و نگهداری سازه های فلزی را انجام می دهد. همچنین با استفاده از مواد و تجهیزات با کیفیت، تعمیرات و نگهداری سازه های فلزی را مطابق با استانداردهای بین المللی انجام می دهد.

۳. خدمات مشاوره ای: این کارگاه تخصصی، با استفاده از تیمی مجرب و متخصص، خدمات مشاوره ای را به مشتریان عزیز ارائه می دهد. همچنین با استفاده از روش های نوین و استفاده از بهترین تجهیزات، تعمیرات و نگهداری سازه های فلزی را مطابق با استانداردهای بین المللی انجام می دهد.

۴. گواهی: این کارگاه تخصصی، با استفاده از روش های نوین و استفاده از بهترین تجهیزات، گواهی های لازم را به مشتریان عزیز ارائه می دهد. همچنین با استفاده از مواد و تجهیزات با کیفیت، گواهی های لازم را مطابق با استانداردهای بین المللی انجام می دهد.

۵. خدمات: این کارگاه تخصصی، با استفاده از روش های نوین و استفاده از بهترین تجهیزات، خدماتی با کیفیت و در حد استانداردهای بین المللی را به مشتریان عزیز ارائه می دهد. همچنین با استفاده از مواد و تجهیزات با کیفیت، خدماتی با کیفیت و در حد استانداردهای بین المللی را مطابق با استانداردهای بین المللی انجام می دهد.

تعمیرات و نگهداری سازه های فلزی
کارگاه تخصصی رنگ آمیزی
تعمیرات و نگهداری سازه های فلزی

8800010307

Аймгийн Засаг даргын 2024 оны
68 дугаар сарын 22-ны өдрийн 137 дугаар
Захирамжийн нэгдүгээр хавсралт

**ТЭМЦЭЭНИЙ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ БҮХИЙ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга:	Д.Төмөрбаатар	(Цэргийн штабын дарга хурандаа)
Ажлын хэсгийн нарийн бичиг:	Г.Мөнхбаяр	(Цэргийн штабын дайчилгааны офицер хошууч)
Гишүүдэд:	Х.Баатарзориг	(Санхүү , төрийн сангийн хэлтсийн дарга)
	С.Мөнхжаргал	(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Н.Мэндбаяр	(Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)
	Ц.Лувсанжам	(Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)
	Ж.Амгаланбаатар	(Боловсрол шинжлэх ухааны газрын дарга)
	Ж.Уранчимэг	(Биеийн тамир спортын газрын дарга)
	Г.Лхагважаргал	(Эрүүл мэндийн газрын дарга)
	Ш.Мэндсайхан	(Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга)
	Б.Энхбаяр	(Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч, хурандаа)
	Г.Баасанцог	(Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах офицер, дэд хурандаа)
Г.Цэдэв	(Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт бэлтгэл сургалтын офицер, дэд хурандаа) (Сумдын Засаг дарга нар) (Ерөнхий боловсролын сургуулиудын захирлууд)	

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дугаар сарын 04 -ны өдрийн 159 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ АЙМГИЙН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ" ЦОГЦОЛБОР
ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Тэмцээний зорилго:

Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч үзэл олгон, эх орон, эх хэл, түүх соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэхэд оршино.

Хоёр. Тэмцээнийг зохион байгуулахад оролцох байгууллага:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Цэргийн штаб, Боловсрол шинжлэх ухааны газар, Биеийн тамир спортын газар, сумдын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургуулиуд.

Гурав. Тэмцээн явуулах хугацаа, байрлал:

3.1. Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг дараах 2 үе шаттайгаар зохион байгуулна.

3.1.1. нэгдүгээр үе шат: сумдын Ерөнхий боловсролын сургуулиудын хэмжээнд 2024 оны 03 дугаар сарын 17, 18-ний өдөр тэмцээнийг зохион байгуулж сургууль бүр нэг тасгийг шалгаруулж, аймгийн Засаг даргын нэрэмжит тэмцээнд өрсөлдүүлнэ.

3.1.2. хоёрдугаар үе шат: Аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдөр Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийг түшиглэн зохион байгуулж явуулна.

Дөрөв. Тэмцээний ерөнхий зохион байгуулалт:

4.1. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг зааврын дагуу тэмцээнийг зохион байгуулж, дүнг нэгтгэн гаргана.

4.2. Тасаг нь тухайн сум, багийн харьяалал бүхий ахлах ангийн 16-18 насны 11 (7 эрэгтэй, 4 эмэгтэй) гишүүнтэй байх бөгөөд нөөц эрэгтэй-1, эмэгтэй-1 гишүүнтэй байна.

Тасгийн бүрэлдэхүүн ижил өнгө, загварын дүрэмт хувцас, дүрэмт хувцасны загварт тохирсон хагас түрийтэй гутал, эмнэлгийн анхан шатны тусламжийн цүнхтэй байна. Эмнэлгийн анхан шатны тусламжийн цүнхэнд дараах эм, эмнэлгийн хэрэгсэл байна.

Үүнд:

- 4.2.1. хуруу лент 100 ширхэг,
- 4.2.2. ариун наалт 10 ширхэг,
- 4.2.3. иодтой савх 10 ширхэг,
- 4.2.4. спирттэй арчдас 10 ширхэг,
- 4.2.5. өвчин намдаах тос 1 ширхэг (диклоденк 2%-5 гр),
- 4.2.6. өвчин намдаах эм 1 ширхэг (диклоденк 50 мг),
- 4.2.7. уян боолт хэмжээ тус бүрээс 3 ширхэг,
- 4.2.8. мөчдийн уян чиг 2 ширхэг,
- 4.2.9. цус тогтоох чангалуур 2 ширхэг (хугацаа тавигчтай),
- 4.2.10. тэмдэглэлийн дэвтэр, бал 1 ком (жижиг),
- 4.2.11. гялгар уут (бахардсан тохиолдод үлээлгэх зориулалттай),
- 4.2.12. амны хаалт, үзлэгийн бээлий тус бүр 10 ширхэг,
- 4.2.13. гар ариутгагч 1 ширхэг (жижиг).

4.3.Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тасгийг сумын Засаг дарга, сургуулийн захиргаа, багш дасгалжуулагч нар хариуцан оролцуулах ба тасаг бүр дасгалжуулагч багштай байна.

4.4.Тэмцээнд оролцох тасгийн бүрэлдэхүүнийг харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж Нэгдсэн эмнэлэг болон Эрүүл мэндийн төвийн Ерөнхий эмчийн дүгнэлт гаргуулсан байх бөгөөд гишүүн бүр, гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулсан байна. Тэмцээний явцад томилогдсон эмч, эмнэлгийн ажилтнууд тэмцээнд оролцогчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавина.

4.5.Тасгийн гишүүд өөрийн сумын онцлогийг тусгасан 8 см голч бүхий ялгах тэмдгийг зүүн энгэртээ зүүсэн байна. Тасгийн чиглүүлэгч нь 40х40 см-ийн хэмжээтэй тасгийнхаа онцлогийг илэрхийлсэн дарцагтай байна.

4.6.Тэмцээнийг зохион байгуулах техникийн зөвлөгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд зохион байгуулна. Дасгалжуулагч багш нар тэмцээнд оролцогчдын мэдүүлгийг тодорхой бичиж, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний хуулбар, сурагчийн үнэмлэх, цээж зураг /4,0 х 3,0 см, 2 хувь/-ийг авчран бүртгүүлж гишүүн тус бүрт "Мандат" авна.

4.7.Тасаг бүр сумынхаа туг, далбаатайгаар тэмцээний нээлт, хаалтын ажиллагаанд зохион байгуулалттай оролцоно. Туг далбааны хэмжээ 2,0 х 1,0 метрийн хэмжээтэй байна.

4.8.Сумаас аймагт ирэх, буцах унаа, тээвэрлэлт, холбогдох бусад зардлыг тухайн сумын Засаг дарга, тэмцээний явцын болон шагнал урамшууллын зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

4.9.Тэмцээний бэлтгэл, аймагт ирэх, буцах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах ажлыг тухайн сумын Засаг дарга, сургуулийн захиргаа хариуцаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

Тав. Тэмцээнийг үнэлэх журам:

5.1.Тэмцээний явцад биелүүлэх дасгал, нормативыг дараах баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, үнэлэх журмын дагуу үнэлнэ. Үүнд:

5.1.1.Цогцолбор тэмцээний заавар /хавсрагдсан/;

5.1.2.Цэргийн биеийн тамирын заавар, ЗХЖШ, ЦБТЗ-2018 он;

5.1.3.Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт, ЗХЖШ, 2017 он.

Зургаа. Дүн гаргах, шагнал урамшуулал олгох:

6.1.Тэмцээний дүнг гаргахдаа тасгийн гүйлтийн цэвэр цагаас шагналын хугацааг хасаж, торгуулийн хугацааг нэмэх журмаар хамгийн бага цагаар байр эзлүүлнэ.

6.2.Шагналт (I,II,III) байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнд дараах шагнал, урамшуулал олгоно. Үүнд:

6.2.1.тэргүүн байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг "аймгийн Засаг даргын нэрэмжит шилжин явах цом", "Алтан медаль", "Өргөмжлөл", 1000.000 төгрөгийн мөнгөн шагналаар;

6.2.2.дэд байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг "Мөнгөн медаль", "Өргөмжлөл", 800.000 төгрөгийн мөнгөн шагналаар;

6.2.3.гутгаар байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг "Хүрэл медаль", "Өргөмжлөл", 600.000 төгрөгийн мөнгөн шагналаар зэрэг болно.

6.2.4.тэмцээнд оролцсон бүх сурагчдад аймгийн Засаг даргын талархал гардуулна.

Аймгийн Засаг даргын оны
.....дугаар сарын -ны өдрийн дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ АЙМГИЙН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ" ЦОГЦОЛБОР
ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР**

Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг явуулахад дараах дасгал, нормативуудыг хийж гүйцэтгэнэ.
НЭГ. "ГАРААНЫ ӨМНӨХ АЖИЛЛАГАА"

Тэмцээнд оролцох тасаг нь гарааны өмнөх шүүгчээс өгөгдсөн даалгавар, дасгал, нормативыг тогтоосон байр, талбайд бүрэн бүрэлдэхүүнээрээ биелүүлнэ. Тасгийн захирагч нарын тэмцээнд туслах гишүүн оролцуулж болно.

Тасгууд гарааны өмнө жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, эссе бичлэг хийх, асуулт, хариулт, гэрийн даалгавар /зохиомжит тайлан/-ыг тасгаараа болон сонгогдсон оролцогч хийж гүйцэтгэнэ. Тасгийн захирагч нарын дунд зохион байгуулах тэмцээнд Тасгийн захирагч, багийн эрэгтэй-1, эмэгтэй-1 гишүүний хамт оролцоно.

А. "Жагсаалын үзүүлэх тоглолт":

Жагсаалын үзүүлэх тоглолтод дараах үзүүлэлтүүд багтана. Жагсаалыг үзүүлэх тоглолтын үргэлжлэх хугацаа 6-7 минут байна.

1. Зэвсэггүй жагсах үеийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн;
2. Ёсолж хүндэтгэх, жагсаалаас гарах, жагсаалд орох, захирагч /дарга/-д очих, илтгэх, буцах ажиллагаа;
3. Тасгийн жагсаалын жигдрэлт;
4. Жагсаал удирдах дохио;
5. Жагсаалын дуу.

Тасаг бүр Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээний сүлд дуу (Хөгжим Т.Мөнхтунгалаг, Шүлэг Г.Ганбат)-г заавал сурсан байхаас гадна, тасгийн захирагч доорх 10 жагсаалын дуунаас 1 жагсаалын дууг сугалж, дууг тасгийн бүрэлдэхүүн дуулна. Үүнд:

1. "Манай цэргийн жавхаа" хөгжим Ш.Гунаажав, шүлэг Б.Жалбуу
2. "Монгол Улсын төлөө зүтгээ" хөгжим Б.Нямдорж, шүлэг Г.Пүрэвдорж
3. "Энхийн үйлсэд Монгол цэрэг" хөгжим Т.Насанбуян, шүлэг Г.Баатарнум
4. "Дэлхийд данстай Монгол цэрэг" хөгжим О.Эрдэнэцог, шүлэг Г.Ганбат
5. "Баярын жагсаал" хөгжим Г.Ганбат, шүлэг Г.Ганбат
6. "Торгон хилийн зүг" хөгжим Т.Чимэддорж, шүлэг Ш.Сүрэнжав
7. "Цэргийн тухай дуу" хөгжим Д.Дашням, шүлэг С.Дашдооров
8. "Жанжин тугийн намираа" хөгжим Т.Мөнхтунгалаг, шүлэг Т.Бат-Очир
9. "Түүхт хил" хөгжим Я.Мөрдорж, шүлэг З.Пунцаг
10. "Улаан туг" Ардын журамт цэргийн дуу

Үнэлэлт:

Жагсаалын үзүүлэх тоглолтын дүнг гаргахдаа Тасгийн захирагчийн жагсаал удирдах ур чадвар, жагсаалын элементийн гүйцэтгэл, тасгийн жигдрэлт, сургагдсан байдлыг тооцон үзүүлэлт тус бүрт 5 минут хүртэл шагнал өгнө. Үнэлгээг үндсэн 5 үзүүлэлтийн нийлбэрийн дунджаар бодож хугацааны шагнал өгнө. Жагсаалын явц дахь алдаа бүрд 20 секундийн торгууль онооно.

Б. "Гардан тулааны үзүүлэх тоглолт":

Гардан тулааны үзүүлэх тоглолтод дараах үзүүлэлтүүд багтана. Гардан тулааны үзүүлэх тоглолтын үргэлжлэх хугацаа 6-7 минут байна.

1. Зэвсэггүй гардан тулааны хөдөлгөөн, ката-нууд;
2. Гарын цохилт, хөлийн өшиглөлтийн техникийн үзүүлэлтүүд;

3. Итгэл үнэмшил, зохиомж.

Үнэлэлт:

Гардан тулааны үзүүлэх тоглолтын дүнг гаргахдаа Тасгийн захирагчийн удирдах ур чадвар, дасгалын гүйцэтгэл, тасгийн жигдрэлт, сургагдсан байдлыг тооцон үзүүлэлт тус бүрт 5 минут хүртэл шагнал өгнө. Үнэлгээг үндсэн 5 үзүүлэлтийн нийлбэрийн дунджаар бодож хугацааны шагнал өгнө. Тоглолтын явц дахь алдаа бүрд 20 секундийн торгууль онооно. Өөрийгөө гэмтээх, шарх авах тохиолдолд тус бүр 2 минутын торгууль онооно.

В. "Тасгийн захирагчийн тэмцээн":

Тасгийн захирагч нар биеийн тамирын болон галын бэлтгэлийн норматив, тасгийн бүрэлдэхүүнээс үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах бэлтгэлийн тус бүр нэг дасгал, нормативыг сугалаагаар биелүүлнэ.

Биеийн тамирын ЦБТЗ-18 зааврын 19 дүгээр дасгал /гар дээр тулан хэвтэж суниах/, ЦБТЗ-18 зааврын 7 дугаар дасгал /дүүжинд суниах/, ЦБТЗ-18 зааврын 20 дугаар дасгал /гэдэсний таталт/-ыг биелүүлнэ.

Үнэлэлт:

Дасгалын гүйцэтгэл тус бүрд "онц" биелүүлбэл 1 минут, "сайн" биелүүлбэл 40 секунд, "дунд" биелүүлбэл 20 секундийн шагнал, "муу" биелүүлбэл 1 минутын торгууль онооно.

Г. "Эссе бичлэгийн уралдаан":

Тасгийн захирагч бүр шүүгчээс тогтоосон хугацаанд, сонгогдсон сэдвийн хүрээнд эссе бичлэг бичнэ. Эссе бичлэгийн ургалдаанд дараах сэдвүүдээс сугалаагаар сонгон авч бичнэ. Үүнд:

1. Миний мэдэх Монгол Улсын Зэвсэгт хүчин;
2. Миний төрсөн орон хамгийн сайхан;
3. Монголын түүхэн дэх аугаа цэргийн жанжин;
4. Миний эх орон-миний мөрөөдөл;
5. Миний аав энхийг сахиулагч;
6. Монгол бахархал;
7. Тусгаар тогтнолын үнэ цэнэ;
8. Дэлхийн түүхэн дэх миний эх орон.

Үнэлэлт:

1 дүгээр байрт 3 минут, 2 дугаар байрт 2 минут 30 секунд, 3 дугаар байрт 2 минут, 4 дүгээр байрт 1 минут 30 секунд, 5 дугаар байрт 1 минутын шагнал өгнө.

Е. "Асуулт хариултын тэмцээн":

Монголын түүх, цэрэг-эх орны сэдэвт асуулт, хариултын тэмцээнд тасгийн бүх бүрэлдэхүүн оролцоно. Шүүгчдийн бүрэлдэхүүнээс боловсруулан бэлтгэсэн 1-10 хүртэлх асуултад зөв хариулснаар багтаа оноо авч, асуултад хариулаагүй тохиолдол бүрт оноо хасах журмаар явагдана.

Үнэлэлт:

Зөв хариулт тус бүрт 30 секундийн шагнал, буруу хариулт бүрд 20 секундийн торгууль тус тус өгнө.

Ё. "Урлаг":

Тасаг бүр урлагийн зохиомжит тоглолтыг 10 минутын хугацаанд гүйцэтгэхээр урьдчилан бэлтгэж ирсэн байх бөгөөд зохиомж нь эх хэл, эх орон, түүх, соёл, ёс заншлаа түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн байна. /дуу, шүлэг, бүжиг, жүжиг г.м./ Шүүгчийн комисс даалгаврыг шалгаж байр эзлүүлэн, эхний 5 байрт 1-3 минутын шагнал өгнө.

Үнэлэлт:

1 дүгээр байрт 3 минут, 2 дугаар байрт 2 минут 30 секунд, 3 дугаар байрт 2 минут, 4 дүгээр байрт 1 минут 30 секунд, 5 дугаар байрт 1 минутын шагнал өгнө.

ХОЁР. "МАРШ, ГҮЙЛТИЙН ТЭМЦЭЭН":

Тасгууд сугалааны дарааллаар 15 минутын зайтайгаар гараанаас гарч 6 км замыг туулж, гүйлтийн явцад 7 цэг дээр өгөгдсөн дасгалыг гүйцэтгэнэ. Марш,

гүйлтийн тэмцээний явцад гүйцэтгэх дасгалын цэг дээр тасгууд давхар ирсэн тохиолдолд цэгийн шүүгч нар эхний тасгийг цэгээс гарах хүртэл дараагийн тасгийн цагийг зогсоож, хугацааг тухайн тасгийн гүйлтийн цэвэр цагаас хасаж тооцно.

Гарааны өмнө тасгийн бүрэлдэхүүний иргэний үнэмлэх, сурагчийн үнэмлэх, хувцас хэрэглэл, анхан шатны тусламжийн цүнх, гэнэтийн ослын даатгалын баримт бичиг зэрэгт үзлэг явуулна. Илэрсэн зөрчил бүрд 30 секундийн торгууль онооно.

Нэгдүгээр дасгал: "Гранат шидэлт":

Тасаг гараанаас гарч хоёрын цуваагаар гранат шидэлтийн талбайд очиж дараах дасгалыг боловсруулна. Үүнд:

- эрэгтэй гишүүд 25 метр холд байрлах 1, 3, 5 метрийн диаметр бүхий онооны тойрогт 600 гр жинтэй сургуулийн Ф1 гар гранатыг шуудуунаас, босоо байдлаас;

- эмэгтэй гишүүд 10 метр өргөн, 20 метр холын тэмдэглэгээ бүхий зурваст 600 гр жинтэй сургуулийн Ф1 гар гранатыг холд ил газраас, босоо байдлаас шиднэ.

Үнэлэлт:

Гранатыг 1 метрийн диаметртэй тойрогт оновол 1 минут, 3 метрийн тойрогт оновол 40 секунд, 5 метрийн тойрогт оновол 20 секундийн шагнал, холд 20 метрээс цааш шидвэл 1 минут шагнал өгнө.

Тойргийн гадна, 20 метрээс дотогш буюу зурвас /10 м-ийн коридор/-ын гадна шидсэн гранат тус бүрд 1 минутын торгууль онооно.

Хоёрдугаар дасгал: "Саадын зурвас":

Тасаг цааш хөдөлгөөнийг үргэлжлүүлэн "Ерөнхий цэргийн саадын зурвас"-ыг хэсэгчилсэн дараах байдлаар туулна.

Тасаг 8 м урт дамнуургаар гүйж гараад 2 м-ийн ханыг давна. Саадын зурвасыг туулахдаа багийн бүрэлдэхүүний тусламжийг авч болно.

Үнэлэлт:

Саадын зурвасын аль нэг элементийг туулж чадаагүй буюу тойрч гарсан тохиолдол тус бүрд 30 секундийн торгууль онооно.

Гуравдугаар дасгал: "Буудлагын дасгал":

Тасгийн бие бүрэлдэхүүн буудлагын талбайд очиж, гельбластер /хийн/ буугаар цель /шаар, шил г.м./-ийг 10-15 метрт буудаж устгана.

Үнэлэлт:

Устгагдсан цель бүрд 1 минутын шагнал өгч, устгагдаагүй цель бүрд 30 секундийн торгууль онооно.

Дөрөвдүгээр дасгал: "Тактикийн ажиллагаа":

Тасаг шүүгчийн тогтоосон заагаас дохиогоор гинжинд тарна. Гинжинд тарсан үед хүн бүрийн хоорондын завсар "Байлдааны дүрэм"-д заасны дагуу /6-8 м буюу 10-12 алхам/ байна.

Тэмдэглэсэн заагт ирмэгц цөмийн дэлбэрэлтийн гялсхийлтээр ажиллаж, Тасгийн захирагчийн командаар 2 жигүүрээс 50 м-ийн үсрэлттэйгээр давшиж, 25 м торон саадыг мөлхөлтөөр туулан харилцах шуудууны баруун талд байгаа дарцгийг тойрч цаашид гүйлтээ үргэлжлүүлнэ. Тактикийн ажиллагааг Тасгийн захирагчийн ажиллагаа, заагуудад хүч задлах, байлдааны талбарт хөдөлгөөн үйлдэх ажиллагаа гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

Үнэлэлт:

Үзүүлэлт бүрт 3 минут хүртэл шагнал өгч, нийлбэрийн дунджаар шагнал болон торгууль онооно.

Тавдугаар дасгал: "Эмнэлгийн норматив":

Тасгийн эмнэлгийн зааварлагч, шүүгчийн томилсон тасгийн нэг гишүүнтэй хамт шархтанд эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлж, Цэргийн хүн эмнэлгийн бэлтгэлийн 3 дугаар норматив /цус гоожилтыг тогтоогч резин

чангалуурыг гуянд тавих/, 5 дугаар норматив /биеийн дээд болон төгсгөл хэсгийн яс хугарах үед гарын доорх материалаар чиг тавих/-ыг гүйцэтгэн шархтныг аюулгүй зайд татан гаргаж, Эмнэлгийн байранд хүргэнэ.

Үнэлэлт:

Гүйцэтгэсэн нормативыг "онц" гүйцэтгэвэл 1 минут, "сайн" гүйцэтгэвэл 30 секунд, "дунд" гүйцэтгэвэл 10 секундын шагнал өгч, "муу" үнэлгээ авбал 1 минутын торгууль онооно.

Зургаадугаар дасгал: "Цэргийн байр зүйн норматив":

Тасаг газар орон дээр азимутаар хөдөлгөөн үйлдэж, урьдчилан бэлтгэсэн 2 цэгийг GPS-ийн тусламжтайгаар цэг олох нормативыг тасгийн зохион байгуулалтаар 4 хүртэлх минутын хугацаанд биелүүлнэ.

Үнэлэлт:

Хоёр цэгийг олбол 2 минутын шагнал, 1 цэгийг олбол 1 минутын шагнал өгч, олоогүй тохиолдолд 2 минутын торгууль онооно.

Долоодугаар дасгал: "Химийн норматив":

Тасаг тэмдэглэсэн заагт ирмэгц шүүгчийн дохиогоор үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах бэлтгэлийн 1 дүгээр норматив /газ эсэргүүцэгч өмсөх/-ийг биелүүлэн 100 м хордсон газар орныг газ эсэргүүцэгч багтайгаа туулж, утаа бүхий майханд 2 дугаар норматив /хордсон агаарт газ эсэргүүцэгч ашиглах/-ыг биелүүлж, 2 минут болоод майхнаас гарч шалгуулна.

Үнэлэлт:

нэгдүгээр норматив: Тасгаараа "онц" биелүүлбэл 3 минут, "сайн" биелүүлбэл 2 минут, "дунд" биелүүлбэл 1 минутын шагнал өгнө. "Муу" үнэлгээ авсан тохиолдолд 3 минутын торгууль оноож, үнэлэлт бууруулах алдаа гаргасан хүн бүрийг 20 секундээр торгоно.

хоёрдугаар норматив: Утаа амьсгалын эрхтэн буюу нүдэнд нөлөөлж үүрэггүй үнэлэлт авсан хүн бүрийг 1 минутаар, хордолт авсан хүнийг майхнаас гарахыг хориглосон хүн бүрд 3 минутын торгууль оноож, үнэлэлт бууруулах алдаа гаргасан хүн бүрийг 20 секундээр торгоно.

Тасгийн бүрэлдэхүүн газ эсэргүүцэгч багийг уутанд хийж, цааш хөдөлгөөнөө үргэлжлүүлэн барианд зохион байгуулалттайгаар орно.

Барияны цагийг тасгийн сүүлийн гишүүнээр тооцно. Барианд хүн дутуу орох, тасгийн 11 хүнээс гадна өөр хүн дагаж барианд орвол 5 минутын торгууль онооно. Тасгуудыг маршид гүйсэн цэвэр цагаар нь тооцон эхний 5 байр эзлүүлнэ.

Үнэлэлт:

1 дүгээр байрт 5 минут, 2 дугаар байрт 4 минут, 3 дугаар байрт 3 минут, 4 дүгээр байрт 2 минут, 5 дугаар байрт 1 минутын шагналыг тус тус өгч, тасгийн ерөнхий дунд оруулан тооцно.

Аймгийн Засаг даргын 2024 оны
14 дугаар сарын 14 -ны өдрийн 14 дугаар
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ"
ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ШАГНАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Тэмцээн уралдааны төрөл	Медаль, өргөмжлөл	Зарцуулагдах төсөв	
1	Цэрэг спортын "Дөл" цогцолбор тэмцээн	Медаль-42 ш	7500х42	315000
		өргөмжлөл-3ш	50000х3	150000
		1-р байр 1		1000.000
		2-байр 1		800.000
		3-р байр 1		600.000
		Талархал 150 ш	1500х150	225000
		Шатахуун 50 л	100х3180	318000
		Бусад зардал	200000	200000
		Нийт		3608000

__оОо__